



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 6 сарын 22 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

### “Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх тухай”

Монгол Улсад сүүлийн 19 жилийн хугацаанд гамшиг, аюулт үзэгдэл, ослын нийт 71718 тохиолдол бүртгэгдсэний улмаас 4123 хүн амь эрсдэж, 15091,8 мянган толгой мал хорогдон 1387,3 тэрбум төгрөгийн бодит хохирол учирсан байна.

Үүнээс объектын болон ой, хээрийн түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, ган, зуд, үер, ус, ахуйн ослын дуудлага дийлэнх хувийг эзэлж байна. Дээрх гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, мэдлэг ойлголтыг иргэн бүрт хүргэх, өөрийгөө болон бусдыг авран хамгаалах арга зүйд сургаж дадлагажуулах ажлыг эрчимжүүлэх хэрэгцээ бодитой оршиж байна.

Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн 3.2.9 дахь заалтад “олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээлэл, сургалт, сурталчилгааг сар бүрийн сүүлийн 7 хоногийн “Пүрэв” гарагт тодорхой давтамжтайгаар нийтэд түгээх” гэсэн нэмэлт өөрчлөлт оруулж Засгийн газрын 2023 оны 78 дугаар тогтоолоор батлуулсан.

Иймд Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор ДААЛГАХ нь:

Нэг. Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, Олон нийттэй Харилцах газар,  
Боловсрол, шинжлэх ухааны яам, Соёлын яам, Хөдөлмөр, нийгмийн  
хамгааллын яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Аймаг, нийслэл, сум,  
дүүргийн Засаг дарга, Харилцаа холбооны зохицуулах хороо,  
Төрийн захиргааны бүх шатны байгууллага,  
хуулийн этгээдийн дарга нарт;

1.1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13.3.3 (сум, дүүргийн мэргэжлийн анги, гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн сургалтыг тухайн шатны Засаг дарга), 13.3.4 (иргэний сургалтыг тухайн баг, хорооны Засаг дарга), 13.3.6 (оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн сургалтыг батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу тухайн шатны боловсролын байгууллага), 13.3.7 (хуулийн этгээдийн ажилтны сургалтыг тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан хариуцан зохион байгуулна) дахь заалт, “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн 3.2.9 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Онцгой байдлын байгууллагаас бэлтгэсэн хичээлийг 30 хүртэл минутын хугацаанд тогтмол явуулж хэвших;

Хоёр. Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, Олон нийттэй  
Харилцах газарт;

2.1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 16.3 (Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлгийг харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах үүрэгтэй), Галын аюулгүй байдлын тухай хуулийн 7.3 (Хэвлэл мэдээллийн байгууллага гал түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээлэл, мэргэжлийн зөвлөгөөг олон нийтэд үнэ төлбөргүй хүргэнэ) дахь заалтын хэрэгжилтийг хангахад дамжлэг үзүүлж олон нийтийн телевиз, хэвлэл мэдээллийн байгууллагыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах.

2.2. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлын тооцоо гаргаж, төсөвт суулгах, хэрэгжилтийг хангах.

Гурав. Боловсрол, шинжлэх ухааны яам, Соёлын яам,  
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд:

3.1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/181 дүгээр тушаалаар баталсан “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах;

3.2. Их, дээд сургууль, коллеж, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутан, сурагчдад “Гамшгаас хамгаалах менежмент”-ийн мэдлэг олгох сургалтыг заавал судлуулах, чанар, үр дүнд хяналт тавьж мэргэжлийн байгууллагатай бодлогын түвшинд хамтран ажиллах;

3.3. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрт “Аюулгүй амьдрах ухаан”-ны мэдлэг олгох сургалтыг оруулж, чанар, үр дүнд хяналт тавьж ажиллах;

3.4. Тусгай хэрэгцээт иргэдэд аюулгүй амьдрах ухааны мэдлэг, ойлголт олгох сургалт явуулахдаа тэдний нас, сэтгэхүйн онцлог, тусгай хэрэгцээнд тохируулсан хөтөлбөр, төлөвлөгөө гаргах, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах;

Дөрөв. Харилцаа холбооны зохицуулах хороонд:

4.1. Хэвлэл мэдээллийн байгууллага /телевиз, сонин, сайт/-тай хамтран ажиллах гэрээ, санамж бичигт гамшгийн эрсдэлийг бууруулах, иргэд, олон нийтэд гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, аюулгүй амьдрах ухааны мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг, шторкыг түгээх, сурталчилгааг эрчимжүүлэх чиглэлээр тусгайлан зааж, тогтмол, давтамжтайгаар нэвтрүүлэх, хяналт тавих;

Тав. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга,  
дарга нарт:

5.1. Сум, дүүргийн мэргэжлийн анги, гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, иргэдийн сургалтыг тогтмол зохион байгуулж, чадавхжуулах;

5.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах, мэдлэг олгох сургалт, дадлагыг зохион байгуулах зардлыг жил бүр орон нутгийн төсөвт тусган, хэрэгжилтийг хангах;

5.3. Сум, дүүргийн хэмжээнд иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтын танхим, гарын авлага хэвлэх

зардлыг шийдвэрлэх чиглэлээр олон улсын байгууллагатай төсөл, хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлж, хамтран ажиллах.

5.4. Монгол Улсын Шадар сайдын улсын хэмжээнд зохион байгуулахаар баталсан гамшгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, өдөрлөг, аяны удирдамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

5.5. Засаг даргын дэргэдэх агентлаг, хэлтэс, албадын удирдлагад гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтыг хуваарь, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл өгч, хяналт тавьж ажиллах;

Зургаа. Төрийн захиргааны бүх шатны байгууллага,  
хуулийн этгээдийн дарга нарт:

6.1. Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтнуудад гамшгийн эрсдэлийг бууруулах, мэдлэг олгох сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулах;

6.2. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг чадавхжуулах;

Долоо. Онцгой байдлын ерөнхий газарт:


7.1. Олон нийтэд гамшгаас хамгаалах сургалт, дадлага зохион байгуулах сургалтын материал, хэрэглэгдэхүүн, ном, гарын авлагын эхийг бэлтгэх, хүрэлцээг нэмэгдүүлэхэд олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагуудтай хамтран ажиллах.

7.2. Гамшгийн эрсдэлийг үнэлэх, бууруулах чиглэлээр мэргэжил, арга зүйгээр хангаж, зөвлөн туслах үйлчилгээг тогтмол үзүүлэх;

7.3. Хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдийг гамшгаас хамгаалах сургалтад өргөнөөр хамруулах, тэднийг аюулгүй амьдрах ухаанд сургаж, дадлагажуулахад дэмжлэг үзүүлэх,

7.4. Гамшгийн төрөл бүрээр иргэд, олон нийтэд явуулах хичээлүүдийг цахим хэлбэрээр /видео/ бэлтгэж, орон нутаг, төрийн бүх шатны байгууллага, хувийн хэшлийн ажилтан, албан хаагчдад сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.

ДАРГА



С.АМАРСАЙХАН

УХАД16Р